

БАТЛАВ:  
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ш. БАЯНМӨНХ



БАТЛАВ:  
БАЯН ЦАГААН НУУР ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ Д.МАГСАРЖАВ



**АЖЛЫН ГУТАЛ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ**

Дугаар № 22 / 2022

20 02 оны 03-р сарын 09 өдөр

Улаанбаатар хот

Нэг талаас “АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Ш.Баянмөнх нөгөө талаас Баян цагаан нуур ХХК-ийн захирал Д.Магсаржав /цаашид “Нийлүүлэгч” гэх/ нар Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйл, 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ”гэх) байгуулав.

**Нэг. Гэрээгээр нийлүүлэх зүйл, нөхцөл**

1.1 Нийлүүлэгч нь “Ажлын гутал” (цаашид “бараа” гэх)-ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох нэгдүгээр хавсралтанд заасан нэр төрөл, нэг бүрийн үнэ, техникийн үзүүлэлт, стандартын дагуу Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад нийлүүлнэ.

**Хоёр. Бараа нийлүүлэх хугацаа**

2.1 Нийлүүлэгч нь барааг гэрээнд хоёр тал гарын үсэг зурж баталгаажуулснаас хойш **30** хоногийн дотор багтаан нийлүүлнэ.

**Гурав. Үнэ төлбөрийн нөхцөл**

3.1 Энэ гэрээний нийт үнэ 29,744,000 /хорин есөн сая долоон зуун дөчин дөрвөн мянга/-н төгрөг бөгөөд Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад хүргэх, тээврийн зардал, НӨАТ бүгд шингэсэн байна.

3.2 Захиалагчаас нийлүүлэгчид урьдчилгаа төлбөр төлөхгүй.

3.3 Төлбөрийг бараа нийлүүлж дууссан гүйцэтгэлээр олгоно.

3.4 Барааг хүлээн авсаны дараа бараа хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн акт, нийлүүлэгчийн нэхэмжлэлийг үндэслэн 90 хоногийн дотор төлбөрийг нийлүүлэгчийн Хас банк 5000253526 тоот дансанд шилжүүлнэ.

**Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага**

4.1 Нийлүүлэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандаа нийлүүлээгүй барааны нийт үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам төлөх ба нийт алдангийн үнийн дүн гэрээний нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.

8.2 Нийлүүлэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа буюу ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.

### Ес. Бусад нөхцөл


- 9.1 Талуудын аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 7 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.
- 9.2 Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3 Гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэж, Захиалагч 2 хувийг Нийлүүлэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4 Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд сунгаж болно.
- 9.5 Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр байна.
- 9.6 Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмж засварласан эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн оруулга засвар нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
- 9.7 Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.


#### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:


АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН

СЭЗХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ  
НЯГТЛАН БОДОГЧИЙН АЖИЛ ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ө.УДВАЛ  
Гарын үсэг: 

ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  
Г. ЭРДЭНЭБИЛЭГ  
Гарын үсэг: 

ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  
П.ЗОРИГОО  
Гарын үсэг: 

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН  
Г. САРУУЛ  
Гарын үсэг: 

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН:  
ЦАХИМ ХУДАЛДАН АВАЛТ ХАРИУЦСАН  
АЖИЛТАН  
Г.БАЯРЧИМЭГ  
Гарын үсэг: 

Хаяг: Улаанбаатар хот  
Баянзүрх дүүрэг, 8-р хороо, ус 15-1-1  
Утасны дугаар: 77111251 РД: 6021646

#### НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

БАЯН ЦАГААН НУУР ХХК-ИЙН

Д.МАГСАРЖАВ

Гарын үсэг: 



Хаяг: Улаанбаатар хот: Баянзүрх дүүрэг Их дарь эх 1-18 тоот  
Утас 99190879  
РД: 2874423

тоот гэрээний хавсралт

Ажлын гутлын үнийн жагсаалт

№	Бараа материалын нэрс	Марк	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /НӨАТ/	Үнэ
1	Ажлын гутал /өвлийн/		хос	138	132,000	18,216,000.00
2	Ажлын гутал /зуны/		хос	131	88,000	11,528,000.00
	Дүн					29,744,000.00

Баянцагаан нуур ХХК-ийн

захирал

Д.Магсаржав

Амгалан дулааны станц ТӨХК-ийн

Цахим худалдан авалт хариуцсан ажилтан

Г.Баярчимэг

